

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДЭЭС**  
**НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД**  
**ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
/2021 оны 2 дугаар улирлын байдлаар/

2021.06.23

Багахангай дүүрэг

**Нэг. Хууль эрх зүйн хүрээнд**

Тус дүүргийн “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, 2009 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” А/1086 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 21 дүгээр хурлын тэмдэглэлийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөн Ковид 19 цар тахал өвчинтэй холбогдуулан иргэдээс гаргасан өргөдөл, гомдол саналыг цахим хуудас /[www.bagakhangai.ub.gov.mn/](http://www.bagakhangai.ub.gov.mn/), нээлттэй утас /70491019, 70491004/ болон амаар хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна

**Хоёр. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр**

2021 оны 06-р сарын 23-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан нийт 100 өргөдөл ирснээс ЗДТГ-т 24 /ажилд орохыг хүссэн 10, орон сууц хүссэн 7, тусламж дэмжлэг хүссэн 5/, бусад 2, ХХҮХ 31, Татварын хэлтэс 1, Газар зохион байгуулалтын албанд 14, ГБХЗХХ 3, ЭМТ 18 тус тус ирсэн байна. Үүнээс санал 4, НҮНТ-өөр дамжиж ирсэн 1 гомдол байна. Иргэдэд хариуг утсаар 49, цахим системээр 22, албан бичгээр 24 удаа өгсөн байна. Саналын хайрцаг, албаны цахим шуудан, утас, факсаар ирсэн өргөдөл гомдол, санал байхгүй.

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 15 хоног, 10 цаг 45 минут байна.

Ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, иргэдэд тухай бүр хариуг бичгээр болон амаар өгч, ажиллаж хэвшсэн бөгөөд шийдвэрлэлт 98%-тай байна.

Агуулгаар нь авч үзвэл ажилд орох, гэр орон хүссэн, нийгмийн халамж, тусламж дэмжлэг хүссэн өргөдөл 75 хувийг эзлэж байна.

Ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, иргэдэд тухай бүр хариуг бичгээр болон амаар өгч, ажиллаж хэвшсэн бөгөөд шийдвэрлэлт 95%-тай байна.

Тусгай дугаарын утсаар дамжуулан гаргасан 1 гомдол байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан “Явуулын нэг цонхны үйлчилгээ”, “Нээлттэй хаалганы өдөр”, “Иргэн таныг сонсьё” уулзалт болон дээд шатны болон дүүргийн удирдлагуудын иргэдтэй хийх уулзалт зохион байгуулаагүй байна.

**Гурав. Иргэдийг мэдээ, мэдээллээр хангах чиглэлээр**

Дүүргийн вэб сайтад өргөдөл, гомдол, санал гэсэн цэс байршуулан, ажилтны нэр, утасны дугаар, иргэд хүлээн авах хуваарийг тавьж, иргэдийн санал хүсэлтийг нээлттэй хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн 2-р улирлын өргөдөл гомдлын тайлан, мэдээг [www.bagakhangai.ub.gov.mn](http://www.bagakhangai.ub.gov.mn) сайтад байршууллаа.

Тус дүүргийн 1-р хороонд байрлах 129 айлын орон сууц ашиглалтад орох гэж байгаатай холбогдуулан Орон сууц хүссэн иргэдийн тоо өссөн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг агуулга, хэлбэрээр ангилж 1, 2, 3 дугаар хүснэгтээр харуулж, хавсаргав.

ХЯНАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА *Эрдэнэтуяа* Д.ЭРДЭНЭТУЯА

ТАЙЛАН ГАРГАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН *С.Цэнд-Аюуш* С.ЦЭНД-АЮУШ



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ИРГЭДЭЭС  
 НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
 ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ  
 /2021 оны 2 дугаар улирлын байдлаар/


2021.06.23

Багахангай дүүрэг

№	Байгууллагын нэр	Нийт өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /Хувь/
1	ЗДТГ	24	24	-	-	-	100%
2	Хороод	-	-	-	-	-	-
3	ХХҮХэлтэс	31	27	-	-	4	87
4	Татварын хэлтэс	2	2	-	-	-	100%
5	Газар зохион байгуулалтын алба	15	15	-	-	-	100%
6	ЭМТөв	18	15	-	-	3	83.3%
7	ГБХЗХХэлтэс	5	4	-	-	1	100%
<b>Нийт</b>		<b>95</b>	<b>87</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>8</b>	<b>95%</b>

ХЯНАСАН:  
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
 ХЭЛТСИЙН ДАРГА *Д.Эрдэнэтуяа* Д.ЭРДЭНЭТУЯА

НЭГТГЭСЭН  
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
 МЭРГЭЖИЛТЭН *С.Цэнд-Аюуш* С.ЦЭНД-АЮУШ



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН ХЭЛБЭР  
/2021 оны 2 дугаар улирлын байдлаар/


2021.06.23

Багахангай дүүрэг

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс			
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Бусад
1	ЗДТГазар	24	24	-	-	-
2	Хороод	-	-	-	-	-
3	ХХҮХэлтэс	31	31	-	-	-
4	Татварын хэлтэс	2	2	-	-	-
5	Газар зохион байгуулалтын алба	15	15	-	-	-
6	ЭМТөв	18	18	-	-	-
7	ГБХЗХХэлтэс	5	5	-	-	-
Дүн		95	95			-

ХЯНАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА *Д.Эрдэнэтуяа* Д.ЭРДЭНЭТУЯА

НЭГТГЭСЭН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНД-АЮУШ



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/  
/2021 оны 2 дугаар улирлын байдлаар/

2021.06.23

Дүүргийн нэр	Нийт өргөдөл, гомдолд эзлэх тоо, хувь			
Багахангай дүүрэг	Нийт өргөдөл, гомдол, санал 100 ирсэн байна.	Хүсэлт	95	95%
		Гомдол	1	1%
		Санал	4	4%
		Үүнээс		
	Нийгмийн халамжийн үйлчилгээ		31	32.7%
	Ажилд орох		20	21%
	Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой		15	15.9%
	Хөдөлмөр эрхлэлт		5	5.2%
Бусад		24	25.2%	

ХЯНАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА *А. Зоготуяа* Д.ЭРДЭНЭТУЯА

НЭГТГЭСЭН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН *С.Цэнд-Аюуш* С.ЦЭНД-АЮУШ